

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн
аудит

Аудитын код: САГ-2019/81/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
3.1	Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж	10
3.2	Орлогын данстай холбоотой асуудал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРК ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.СОДНОМДАМБА ТАНАА

2019.03.15 № 06/441
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын захирал Ц.Содномдамба Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн орлогын данстай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн програм хангамжтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 7-ноос 2019 оны 3 дугаар сарын 5-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ийн аудитор Т.Хоролсүрэн, Д.Түмэндэмбэрэл, чанарын хяналтын

менежер Ч.Чимгээ, аудиторын туслах Д.Балжирдорж, Г.Хишигдулам нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ 2018 оны санхүүгийн тайланг “Баян ташаагийн эх Аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 1/027 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь “Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах өрсөлдөх чадвар бүхий үндэсний компаниудыг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн өндөр ур чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Харилцаа, холбоо мэдээлэл технологийн газрын тодорхойлсноор Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэл нь төрөөс мэдээллийн технологийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулан

төлөвшүүлэх, шилдэг энтрепренёрийг бэлтгэх, гадаад аутсорсингийн үйл ажиллагааг дэмжих үүрэгтэй.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын удирдлага нь Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Шинжлэх ухаан технологийн тухай хууль

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Бааз” санхүүгийн програм хангамж ашигладаг байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд өөрийн орлогоор санхүүжиж, зарцуулдагтай холбоотой юм.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын материаллаг байдлын суурийг 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 828.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь буюу 8.3 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудалд залруулга хийгээгүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/сая төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	12.0	
	Дүн	2	12.0	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэхбуюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллага нь зорилтот түвшний төлөвлөгөөгөө Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар батлуулдаг бөгөөд тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөө "НьюТур Сафарис" ХХК-тай холбоотой асуудлаас болоод батлагдаагүй байна энэ талаар болон түрээсийн орлогын талаар дараагийн аудитаар авч үзнэ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨҮГ нь тайлант онд үндсэн ажиллагааны орлогоос 636.3 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 181.6 сая төгрөг төвлөрүүлж, нийт 829.0 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй, нийт 10.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Өмнөх онтой харьцуулахад алдагдал буурч, авлага 27 хувиар, өглөг 16.8 хувиар тус тус буурсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заасныг үндэслэн хуулийн хэрэгжилтийг шалган үзэхэд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь 2018 оны санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг болон бусад холбогдох мэдээллүүдийг өөрийн цахим хуудас болон <http://www.shilendans.gov.mn/> сайтанд байршуулсан байна. Мэдээллийг цаг тухай бүрд нь оруулан ажиллаж байна

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 58.4 сая төгрөгийн түрээсийн орлоготой холбоотой 2 зөвлөмж, анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой 1 зөвлөмж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой 1 зөвлөмж нийт 4 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 95 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Нягтлан бодох бүртгэлийн програм хангамж

3.1.1. Илрүүлэлт

Тус байгууллагын одоо ашиглаж байгаа санхүүгийн програм хангамж нь алдаатай ажилладаг, санхүүгийн тайлан мэдээг бүрэн бэлтгэн гаргадаггүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11, 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн мөн “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2: Эрсдэл:

Санхүүгийн програм хангамж нь алдаатай ажилладаг, санхүүгийн тайлан, журналыг буруу бэлтгэн гаргадаг байх

3.1.3: Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн програмыг сайжруулж, шинэчлэх

3.1.4: Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Бааз санхүүгийн програмын апдэйт хувилбарын өөрчлөлтийг нь тестэлж байгаа бөгөөд өөр санхүүгийн програмаар сольж болох хувилбарыг судалж байгаа.

3.2 Орлогын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт

“Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ нь түрээслэгч Оюуны өмч улсын бүртгэлийн газартай 1м2-ыг 7,772.5 төгрөгөөр түрээсийн гэрээ байгуулсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119-р тогтоолын хавсралтад заасан түрээсийн төлбөрийн 1м2-ын жишиг үнэтэй нийцэхгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээгүй, мөн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг баримтлаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дүгээр тогтоолын холбогдох заалтыг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Оюуны өмч улсын бүртгэлийн газар нь түрээсэлж байгаа 4 давхрын хэсгийг балансаас балансад шилжүүлж авахаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандсан байгаа тул уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүртэл түр зогсоосон байгаа ба тогтоол гарах өдөр хүртэлх төлбөрийг түрээсийн журмын дагуу тооцож авна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2018	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	16,354,097.93	29,820,983.31
1.1.2	Дансны авлага	110,046,335.03	80,368,566.32
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	25,227,734.89	65,015,652.51
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,365,180.00	454,847.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	155,993,347.85	175,660,049.14
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,600,187,029.28	3,139,051,183.25
1.2.2	Биет бус хөрөнгө		673,280,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,600,187,029.28	3,812,331,183.25
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,756,180,377.13	3,987,991,232.39
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	119,398,183.06	102,995,626.58
2.1.1.2	Цалингийн өглөг	267,099.86	247,099.86
2.1.1.3	Татварын өр	213,713,658.97	169,568,216.25
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	19,690,376.50	20,362,759.33
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	353,069,318.39	293,173,702.02
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	5,986,296.39	5,439,453.15
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,986,296.39	5,439,453.15
2.2	Өр төлбөрийн нийт дүн	359,055,614.78	298,613,155.17
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,021,630,200.00	1,021,630,200.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,583,463,801.59	3,213,222,704.68
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	116,214,381.42	789,494,381.42
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	-
		1,324,183,620.66	1,324,183,620.66
2.3.10	Тайлант үеийн ашиг		-
			10,785,588.22
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,397,124,762.35	3,689,378,077.22
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,756,180,377.13	3,987,991,232.39

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	625,199,769.06	636,357,204.43
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	625,199,769.06	636,357,204.43
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	118,288.13	82,263.20
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	844,148,418.61	181,561,615.38
9	Борлуулалт, маркетингийн зардал	53,658,693.28	31,646,734.38
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,480,632,047.67	797,371,289.31
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	12,353,026.05	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	18,031.38	239,578.78
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	129,243.57	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	77,324,566.15	10,777,361.90
19	Орлогын татварын зардал	11,828.80	8,226.32
20	Татварын дараах ашиг (алдагдал)	77,336,394.95	10,785,588.22
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	77,336,394.95	10,785,588.22
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгий дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн Өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	1,583,463,801.59	116,214,381.42	- 1,246,847,225.70	1,474,461,157.31
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				- 77,336,394.96	- 77,336,394.96
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт					
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	1,583,463,801.59	116,214,381.42	- 1,324,183,620.66	1,397,124,762.35
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				- 10,785,588.22	- 10,785,588.22
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт			673,280,000.00		
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		1,629,758,903.09			
17	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	3,213,222,704.68	789,494,381.42	- 1,334,969,208.88	3,689,378,077.22

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<u>761,408,078.12</u>	<u>869,893,879.80</u>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	625,514,550.00	713,055,784.67
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,990,745.00	8,882,457.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	130,902,783.12	147,955,638.13
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<u>769,879,592.62</u>	<u>839,051,959.40</u>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	301,373,681.31	260,779,426.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	90,315,867.45	79,117,079.76
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	14,165,197.75	11,270,455.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	155,535,314.45	132,283,192.96
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,573,554.37	4,756,352.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	66,239,350.00	161,897,018.20
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	329,100.00	111,100.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	137,347,527.29	188,837,335.48
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 8,471,514.50	30,841,920.40
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<u>66,575,176.29</u>	<u>2,038,724.98</u>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	66,456,888.16	1,956,461.78
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	118,288.13	82,263.20
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<u>66,778,000.00</u>	<u>11,014,235.00</u>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		8,976,235.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	66,778,000.00	2,038,000.00
2.2.6			

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 202,823.71	- 8,975,510.02
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	16,505,000.00	6,744,754.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	16,505,000.00	6,744,754.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		15,144,279.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		15,144,279.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	16,505,000.00	- 8,399,525.00
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,830,661.79	13,466,885.38
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,523,436.14	16,354,097.93
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,354,097.93	29,820,983.31

Хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.14	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ			САГ-2019/81/СТА-ТӨҮГ	Мянган төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Санхүүгийн програм хангамж нь алдаатай ажилладаг, санхүүгийн тайлан мэдээг бүрэн бэлтгэн гаргадаггүй.	0	Зөвлөмж	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Содномдамба Д.Цэрэндолгор
“Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ нь түрээслэгч Оюуны өмч улсын бүртгэлийн газартай 1м2-ыг 7,772.5 төгрөгөөр түрээсийн гэрээ байгуулсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119-р тогтоолын хавсралтад заасан түрээсийн төлбөрийн 1м2-ын жишиг үнэтэй нийцэхгүй байна.	12,036.5	Зөвлөмж	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Ц.Содномдамба Д.Цэрэндолгор
Дүн	12,036.5			

